

**АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САРЫН МЭДЭЭ (АУ-1)-Г
ГАРГАХ ЗААВАР**

Ерөнхий зүйл

1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийн тайланг санхүүгийн тайлан тэнцэл хөтөлдөг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, газрууд батлагдсан графикт хугацаанд мэдээлнэ. Шинэ үйлдвэрийн газар, бүрэн ашиглалтанд ороогүй боловч зарим цех тасгууд бүтээгдэхүүн гаргаж байгаа бол бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн өдрөөс эхлэн тайланг гаргана.
2. Үйлдвэрийн газар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын тайланг дараахь үзүүлэлтээр гаргана. Үүнд:
 - Нийт бүтээгдэхүүн
 - Бүтээгдэхүүний нийт борлуулалт, аж үйлдвэрийн борлуулалт
 - Аж үйлдвэрийн ажиллагсад, ажилчид
 - Мэдээлэлд хамрагдсан байгууллагын тоо, хэаа-н тоо
 - Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гол нэр төрлөөр
3. Аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний биет хэмжээг маягтын 3-р баганад, үнийн дүнг 4-р баганад мөн жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний биет хэмжээг 5-р баганад, үнийн дүнг 6-р баганад нөхөж ирүүлнэ. Маягтын 4, 6-р баганын нийлбэр тухайн үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээг харуулах ба маягтын 841-р мөрийн дүнтэй тохирч байна. Телехолболтоор төвд дамжуулахдаа аймаг, хотын статистикийн хэлтэст хүргүүлсэн бүтээгдэхүүний нэр төрлийн шифрийг үндэслэн бүтээгдэхүүний нэр төрлийн биет хэмжээг үнийн дүнгийн хамт мэдээлнэ. Хэрэв гол нэрийн бүтээгдэхүүний жагсаалтанд ороогүй бүтээгдэхүүн шинээр нэмэгдвэл төвөөс тухайн бүтээгдэхүүнд шифр авсны дараа мэдээлнэ.
4. Аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний эцсийн үлдэгдлийг нэр төрөл тус бүр дээр тооцож маягтын 7-р баганад тавина. Энэ нь тухайн сарын нөөцийг харуулна. Эдгээр үлдэгдэл бүтээгдэхүүнүүдийн өртгийн дүнг 841-р мөрийн 7-р баганад тавина.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл (тухайн оны үнээр)

5. Үйлдвэрийн газрын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тодорхойлно. Үйлдвэрлэлийн арга гэж тайлангийн хугацаанд үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүний өртгөөс дотооддоо үйлдвэрлэлийн хэрэгцээнд хэрэглэсэн өөрийн бүтээгдэхүүний өртгийг хасч нийт бүтээгдэхүүнийг гаргахыг хэлнэ.

Нийт бүтээгдэхүүнд дараах зүйлүүдийг оруулна. Үүнд:

- а) үндсэн үйлдвэрийн бүх цех, тасагт үйлдвэрлэгдсэн бэлэн бүтээгдэхүүний өртөг.
- б) аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн бус чанартай ажилд зориулан үйлдвэрлэсэн буюу гадагш борлуулсан хагас боловсруулсан бүтээгдэхүүний өртөг.
- в) туслах чанарын үйлдвэрлэл, тасгуудын бүтээгдэхүүний өртөг (гадагш борлогдсон тохиолдолд)
- г) өөрийн харьяа аж үйлдвэрийн биш аж ахуйн байгууллага буюу бусдын захиалгаар гүйцэтгэсэн аж үйлдвэрийн чанартай ажлын өртөг.
- д) үйлдвэрлэлийн процесс нь урт хугацаанд явагддаг үйлдвэрт бол дуусаагүй үйлдвэрлэлийн өртгийн үлдэгдлийн зөрүүг оруулна.

Бүтээгдэхүүний нийт борлуулалт

6. Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээг бүтээгдэхүүний борлуулалт гэнэ.
7. Хэрэв үйлдвэрийн газар бүтээгдэхүүнээ хүн амд борлуулсан бол бүтээгдэхүүний борлуулалтад худалдааны татварыг хассан хэмжээгээр оруулна.
8. Нийт борлуулалтанд тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалт орно.
9. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ үнийг урьдчилан бүрэн төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулалтанд оруулж тооцно.

Аж үйлдвэрийн борлуулалт

10. Энд зөвхөн тухайн үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг оруулна. Өөрөөр хэлбэл бусад борлуулалт тухайлбал үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний болон үндсэн хөрөнгө, түүхий эд, материал гэх мэт зүйлийг худалдан борлуулсан хэмжээг оруулахгүй.
11. Аж үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт нь гадаад болон дотоод зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн нийлбэртэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл 749-р мөрийн дүн 760 ба 780-р мөрийн нийлбэртэй тэнцүү байна.
12. Тухайн тайлангийн хугацааны ажиллагсад ба ажилчдын дундаж тоог 3-р баганад, жилийн эхнээс өсөн нэмэгдэхийг 5-р баганад нөхнө.
13. Мэдээлэлд хамрагдсан байгууллагын тоог уг маяганд тусгагдсан үйлдвэрийн тоогоор авч маягтын 868-р мөрийн 3-р баганад тавина.

ЭДИЙН ЗАСАГ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Утас: 261560